

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.12 № 308

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ОЙН АНГИЙН
ДАРГА С.ЛХАГВАБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бугат сумын ойн анги нь тайлант онд 28 нэгж талбарын 551 га талбайд тусгаарлалт хийж 41.3 сая төгрөгийн тусгаарлалтын гэрээ байгуулан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгааснаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Бугат сумын Ойн анги нь 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 3 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 94 хувьтай дүгнүүлсэн байна.

6326050462

Бугат сумын Ойн анги нь 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,692.44	4,403.45
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0.00	0.00
	Нийт хөрөнгийн дүн	8,692.44	4,403.45
	Нийт өр төлбөрийн дүн	10,180.89	13,556.05
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-1,424.46	-9,152.61
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,756.44	4,403.45
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	45,403.53	41,801.25
	Үйл ажиллагааны зардлын дүн	49,302.86	49,529.40
	Үйл ажиллагааны үр дүн	-3,899.33	-7,728.15
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-3,899.33	-7,728.15
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,474.87	-1,424.46
	Тайлант оны үр дүн	-3,899.33	-7,728.15
	Эцсийн үлдэгдэл	-1,424.46	-9,152.61
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	41,353.59	44,231.25
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	51,610.91	44,549.93
	Үйл ажиллагааны ЦМГ	-10,257.32	-318.68
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.00	0.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-10257.31585	-318.68
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	2,842.25
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,842.25	2,523.56565
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	0.00	44,549.93
	Урсгал зардал	0.00	44,549.93
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	44,236.25	44,231.25
	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	41,353.59	44,231.25

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,482.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,482.1 мянган төгрөгийн 2 алдаа залруулж 1 зөвлөмжийг хүргүүлэн ажиллаа.

5.1 Төлбөрийн акт Байхгүй

5.2 Албан шаардлага

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу тайлагнах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.3 Зөвлөмж

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд цалинг 36,820.2 мянган төгрөгөөр тусган илэрхийлсэн нь бодит цалингийн тооцоолол 35,788.1 мянган төгрөгийг 1,032.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	1,032.1			1	1,032.1	1	1,032.1				
авлагын тодруулга тайланд 2,270.6 мянган төгрөгөөр илэрхийлсэн нь тулгалтаар 450,0 мянган төгрөгийн авлагыг бууруулаагүй илэрхийлсэн байна.	1	450.0			1	450.0	1	450.0				
Дүн	2	1,482.1										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

